



# МОНГОЛ ДААТГАЛ

## МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 22/08

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн хуулийн 60.1., 62.1.1. болон 62.1.7. дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2. дахь заалт, ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №01 тоот тогтоолын Хавсралт №02 “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ хураасан саналын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монгол Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол Даатгал” ХК-ийн байранд 3 давхарт хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  - 2.1. Монгол Даатгал ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - 2.2. Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
  - 2.3. Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
  - 2.4. 2022 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах;
  - 2.5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлэх өдрийг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2022 оны 03 дугаар сарын 25, 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниудад хүргүүлэх, 2022 оны 03 дугаар сарын 25 болон 04 дүгээр сарын 11-ний өдрүүдэд өдөр тутам гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевиз, компанийн вэбсайт, сошиал хуудсаар мэдээллэх зэргээр хурлын мэдэгдэл,



Буухиа даатгал: +976 7010-1990  
Даатгалын лавлах: +976 1800-1990



www.mongolmaatgal.mn  
insurance@mongolmaatgal.mn

- компанийн цахим, сошиал хуудсаар мэдээлэх зэргээр хурлын мэдэгдэл, зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.
    - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хуулбар;
    - 6.2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тэдгээрийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлт;
    - 6.3. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл танилцуулга;
    - 6.4. Хурлын санал хураах хуудас;
    - 6.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;
    - 6.6. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх танилцуулга;
    - 6.7. Хурлын зар.
  7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр, хурлын дэгийг Хавсралт №02-оор, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
  8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагаар тогтоосугай.
  9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн гишүүн Б.Аюушд даалгасугай.
  10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:  
Дарга: Ч.Бат-Өлзий  
Гишүүд: Д.Дэлгэрмаа
  11. Хурал зохион байгуулах комиссын даргаар А.Санчирмааг томилсугай.
  12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль тогтоомжинд нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс А.Санчирмаад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.

2022 оны 03 дугаар сарын 21-ний Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн эчнээ санал хураалтаар ДЭЭРХ "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай" №22/08 ТОГТООЛЫГ БАТАЛСАН:



№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Громов С.Б.			
2	Огай Н.Ю.			
3	Л.Таня			
4	О.Эрдэнэбулган			
5	О.Цогт			
6	Ц.Оюунжаргал			
7	Д.Отгонбат			
8	Б.Аюуш			
9	Б.Энхтуяа			